

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2018 оны 06-р сарын 11-ны өдөр

№ 01/2018

Мандалговь хот

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоол, Дундговь аймгийн Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг үндэслэн нэг талаас **Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрыг** төлөөлж аймгийн **Засаг дарга О.Бат-Эрдэнэ**, нөгөө талаас **“ҮНЭН АНД” ХХК**-ийг төлөөлж захирал **Т.Төмөрсоль** /цаашид компани гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр талууд байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Компани нь тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
- 1.3. Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Гэрээний хамрах хүрээг Дундговь аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа компанийн доор дурьдсан үйлдвэр, уурхайн төсөл (цаашид “төсөл” гэх)-үүдийн үйл ажиллагааны хүрээнд буюу үйлдвэр залгах хүртэлх хугацаанд орон нутагтай хамтран ажиллах гэрээ гэж ойлгоно. Үүнд:
 - 2.2.1 Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх,
 - 2.2.2 Байгаль орчныг хамгаалах,
 - 2.2.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх,
 - 2.2.4 Орон нутгийн жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих,
 - 2.2.5 Соёлын өвийг хамгаалах
- 2.2 Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхэд Талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. Үүнд:
 - 2.2.1 Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх,
 - 2.2.2 Байгаль орчныг хамгаалах,
 - 2.2.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх,
 - 2.2.4 Орон нутгийн жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих,
 - 2.2.5 Соёлын өвийг хамгаалах
- 2.3 Нутгийн захиргааны байгууллага нь компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 2.4 Талууд хамтран энэхүү гэрээний 2.2.1-2.2.3-т заасан асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.

- 2.5 Компани нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн тэргүүнд үйлдвэр, уурхай байрлаж буй сумын иргэдэд санал болгох, дараагийн шатанд зэргэлдээх сумдын иргэдийг ажлын байраар хангах замаар орон нутгийн иргэдийг авч ажиллуулахад анхаарч ажиллана.
- 2.6 Компани нь төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс орон нутгийн бизнесийг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллана.

ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Ерөнхий зүйлс:

- 3.1.1 Ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрлэл явуулах хугацаанд тус компанид хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж, хяналт тавьж ажиллана.
- 3.1.2 Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар мэргэшсэн ажилтан бэлдэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.3 Шинэ ажлын байр нэмэгдүүлж буй ажил олгогчийг урамшуулан дэмжинэ.
- 3.1.4 Компанийг ашигт малтмал олборлох, үйлдвэр уурхай байгуулах, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой, хэвийн явуулахад орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс шаардагдах үйлчилгээг шуурхай үзүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.5 Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээллэнэ.
- 3.1.6 Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжинэ.
- 3.1.7 Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилна.
- 3.1.8 Татварын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох саналыг хамтран хүргүүлнэ.

3.2 Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.

- 3.2.1 Уурхай, төслийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан хүсэлтийг шуурхай шийдвэрлэн компанийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангана
- 3.2.2 Уурхайн жигд, тогтвортой үйл ажиллагааг хангах, өргөтгөх, ашиглахаар гаргасан хүсэлтийг шуурхай шийдвэрлэн, шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажиллана.
- 3.2.3 Уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай газрыг эзэмших, ашиглах хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 3.2.4 Уурхайн орчны аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.

3.3 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.

- 3.3.1 Компанийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.
- 3.3.2 Компаниас орон нутагт зохион байгуулж байгаа байгаль орчны чиглэлийн танилцуулга, сургалт, өдөрлөгт иргэд, олон нийтийг идэвхитэй оролцуулах.
- 3.3.3 Байгаль орчинд ээлтэй, ногоон бизнесийн үйл ажиллагаа, дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжих, баталгаажуулахад туслах, урамшуулах.

3.4 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.

- 3.4.1 Компанийн захиалгаар мэргэшсэн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.

- 4.5.2 Орон нутгаас санал болгосон хэрэгжүүлэх боломжтой соёлын өвийг хамгаалах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
- 4.5.3 Орон нутгийн уламжлалт ариун дагшин газар буюу сүсэг бишрэлийн хувьд ач холбогдолтой уул, овоо, рашаан ус зэрэг байгалийн онцлог тогтоцуудыг орон нутагтай хамтран хамгаалах, орчны тохижилтыг сайжруулах арга хэмжээг авна.
- 4.5.4 Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтран ажиллана.

4.6 Орон нутгийн бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.

- 4.6.1 Орон нутгийн аж ахуйн нэгжийн санал болгосон бараа нь компанийн “Бараа, материал худалдан авах шалгуур үзүүлэлтүүд” болон үйлдвэрлэлийн хэрэгцээ, зориулалт, шаардлага, чанарын үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд дэмжиж ажиллана.
- 4.6.2 Нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан тохиолдолд эхний ээлжинд худалдан авах бодлого баримтлана.
- 4.6.3 Компанид шаардлагатай бараа, материал нийлүүлэх жижиг дунд үйлдвэрийн төсөл, хөтөлбөрийг судлан хэрэгжүүлэх, боломжтой төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
- 4.6.4 Компани нь төслийн нөлөөлөлд өртсөн малчин өрхөд зориулсан малчдын амьжиргааг сайжруулах хөтөлбөрт хамруулах саналуудыг орон нутгийн удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж ажиллана.
- 4.6.5 Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцаа дэмжлэгийг үзүүлнэ.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТ

- 5.1 Гэрээний хэрэгжилт болон холбогдох хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаа талаар Аймаг, сумдын Засаг дарга, холбогдох төрийн байгууллагууд (МХГ, БОАЖГ, ГХБХБГ), нутгийн иргэд хяналт тавина.
- 5.2 Гэрээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь хянаж шалгана:
- 5.3 Гэрээний хэрэгжилтийг хянах, үнэлгээ хийх болон төслийн талаарх Компани болон орон нутгийн иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх үүднээс гэрээний хэрэгжилтийг асуудал гарсан тухай бичгээр шийдвэрлэнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

- 6.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээг аймгийн болон компанийн цахим хуудсанд байршуулна.
- 6.2 Хамтын ажиллагааны хороо нь Гэрээний биелэлтийг жилд нэг удаа дүгнэх ба тухайн сумын Засаг дарга гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж болно.
- 6.3 Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 7.1 Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 7.2 Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гаргаж ажиллана.
- 7.3 Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

- 7.4 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь компанийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
- 8.2 Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД

- 9.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.2 Давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.
- 9.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 9.4 Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА:**

.....**О.БАТ-ЭРДЭНЭ/**

Шуудангийн хаяг: Дундговь аймаг

Мандалговь хот,

Аймгийн засаг даргын

Тамгын газар

Утас: 9111 4056

**“ҮНЭН АНД” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ:**

.....**Т.ТӨМӨРСОЛЬ/**

Шуудангийн хаяг: УБ хот, СБД

2-р хороо, 5-р хороолол

32-96 тоот

Утас: 8811 4980

Мэйл хаяг: tumursoli@yahoo.com






ХААН БАНК

ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ/Deposit slip

MNT

Огноо/Date:	Салбар/Branch:	Журнал №/Journal №:
09/05/2018	05003	3163470
Дансны дугаар/Account Number:	Валютын код/Currency Code:	
5466042332	MNT	
Данс эзэмшигчийн нэр/Account holder:	Гүйвуулгын код/Code:	
ДУНДГОВЬ АЙМГИЙН УНДЭСНИЙ СУРЬН ХОЛБОО	17117	
Гүйлгээний код/Transaction Code:	Гүйлгээний дүн/Transaction Amount:	
1010 ОРЛОГО БЭЛНЭЭР	*4,000,000.00*	
Гүйлгээний утга/Description:		
УНЭН АНД ХХК-С ХАМТРАН АЖИЛ ГЭРЭЭНИЙ БИЛЭЭЛТ		
Гүйлгээний хураамж/Transaction Fee:	Дансны дугаар/Account number:	Тэмдэглэл/Note
Данснаас/From account:	5466042332	
Бэлнээр/Cash:		
Гүйлгээний дүн/Transaction Amount:		Утасны дугаар/Phone №
4,000,000.00		88114980

Дэвсгэрт / Denomination	Тоо ширхэг / Quantity	Дүн / Amount
1		
5		
10		
20		
50		
100		
500		
1,000		
5,000		
10,000		
20,000	200	4,000,000.00
Бүгд/Total		4,000,000.00



Харилцагч/Customer: ...

Төллөгч/Teller: ...



ХААН БАНК

МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ/TRANSFER SLIP

ОН/YYY CAP/MM ӨДӨР/DD

2018 09 11

Хүлээн авагчийн/Recipient's Information

Банкны нэр, байрлал / Bank name & Location:	Дансны № / Account №:	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual:
ДУ ТОВ ТООЦООНЫ ТОВ	5466042332	ДУНДГОВЬ АЙМГИЙН УНДЭСНИЙ СУРЬН ХОЛБОО
Дүн тоогоор / Amount:	Дүн үсгээр / Amount in words:	
4,000,000.00+	*дөрвөн сая тогрог*	
Валютын код / Currency code:	Гүйлгээний утга, бусад тэмдэглэл / Transaction description & other notes:	Гүйлгээний төрөл / Transaction code:
MNT	УНЭН АНД ХХК-С АЙМАГТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ	1045 ДАНС ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛЭГ


Шилжүүлэгчийн/Sender's Information

Валютын код / Currency code:	Дансны № / Account №:	Нэр (Байгууллага эсвэл иргэн) / Name of organization or individual:
MNT	5163129513	ХАТАГТАЙ ТОРБАТ ТОМОРСОЛЬ
Дүн тоогоор / Amount:	Дүн үсгээр / Amount in words:	
4,000,000.00-	*дөрвөн сая тогрог*	
ХАРИЛЦАГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ/ For Customer use only		
Шилжүүлэгчийн дансны № / Sender's account №:		Гарын үсэг, тамга / Sender's signature, stamp:
Хүлээн авагч банкны нэр, дансны №, дансны нэр / Recipient's bank, account №, account name:		/ 1. /
Мөнгөн дүн тоогоор, гүйлгээний утга / Amount and transaction description:		/ 2. /

Энэ баримтад бичигдсэн мэдээллийн үнэн зөвийг харууцалнаа хуулийн хариуцлагыг хүлээхээ гарын үсгээр баталгаажуулаа. Signing in this form confirm the accuracy of the information provided here and agree to accept any legal responsibility.

Банкны тэмдэглэл/For Bank use only

Шилжүүлэгчийн хураамж / Fee amount:	Банкны ажилтан / Bank staff №:	Журнал №/Journal №:	Огноо/Date:	Гарын үсэг / Signature:	Шилжүүлэгчийн регистрийн дугаар/Customer ID
	17117	1788732	09/11/2018		
<input type="checkbox"/> Бэлнээр/in cash					
<input type="checkbox"/> Данснаас/From account					



ХОЛИМОГ БАГИЙН 2018 ГОВИЙН БҮСИЙ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

2018.09.25

Мандалговь хот

Монголын Үндэсний сурын холбоо, Дундговь аймгийн үндэсний сурын салбар холбоо хамтран Говийн бүсийн чуулга 2018 харваа тэмцээнийг Мандалговь хотод 2018-оны 09 сарын 21-23-ны өдрүүдэд багийн болон цуваа гэсэн хоёр төрлөөр амжилттай зохион байгуулсан.



Уг тэмцээнд өндөр цолтой болон үндэсний сурын спортын цол зэрэгтэй харваачид олноор оролцсон мөн үндэсний сурын холбооноос томилсон шүүгчдийн бүрэлдэхүүн тэмцээний аюулгүй ажиллагаа, шүүгчид болон харваачдын хувийн сахилга бат дэг жаягийг анхааран ажилласан.



ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ТУХАЙ ПРОТОКОЛ

2019 оны 02 сарын 12

Мандалговь хот

Дундговь аймгийн Засаг дарга О.Бат-Эрдэнэ болон Үнэн-Анд ХХК –ний хооронд Баянжаргалан сумын Мануултын хайлуур жоншны орд дээр MV-00001455 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд ашиглалтын үйл ажиллагаа явуулах явцад хамтран ажиллах тухай байгуулсан 01/2018 тоот гэрээний 2018 оны хэрэгжилтийг дүгнэж энэхүү протоколыг үйлдэв.

Үүнд:

1. “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.1.2-р зүйлд тусгагдсанаар нийт ажиллагсдыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд, мөн тэсэлгээний ажил хийх үүрэг бүхий 3-н ажилтныг гэнэтийн ослын даатгалд хамруулсан.
2. “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.1.3-р зүйлд тусгагдсанаар орон нутгийн татварт АМНАТ-т 19,0 гаруй сая төгрөгийг төлсөн.
3. “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.1.6-р зүйлд тусгагдсанаартай аймгийн Үндэсний сурын холбооны үйл ажиллагааны хөтөлбөрт зориулан 2018 оны 9-р сард нийт 8,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
4. “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.2.1-р зүйлд тусгагдсанаар манай компаний тээвэр хийдэг 1 автомашин болон манай уурхайгаас тээвэр хийж буй тээврийн автомашинууд нь Аймгийн Засаг даргын баталсан авто замын маршрутын дагуу тээвэрлэлтийг хийдэг.
5. “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.2.6-р зүйлд тусгагдсанаар сумын төвийн хог хаягдлыг цэвэрлэх ажил энэ жил хийгдээгүй. Манай компани 2012 болон 2013 онд сумын төвийн хог хаягдлын цэгийг шинэчилэн засах, зөөвөрлөх, цэвэрлэх ажилд өөрийн техникийг ажиллуулж байсан.
6. Үнэн Анд ХХК нь 2018 онд уурхайгаа далд аргаар ашиглах бэлтгэл ажил хийсэн бөгөөд өөрийн уурхайн хүдрийн биетийн нөөцийг ашиглах хугацаанд ашиглалтын талбайдаа нөхөн сэргээлт хийх боломжгүй тул мэргэжлийн байгууллагын зөвлөмжөөр уурхайн орчин тойронд мод тарьж дүйцүүлэн нөхөн сэргээлтийг хийхээр төлөвлөж байгаа болно.
7. “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.3.4-р зүйлд тусгагдсанаар уурхайд ашиглаж буй худгийг сумын байгал орчины байцаагчийн хяналтан дор баталгаат тоолуураар тоолууржуулан ашиглаж байгаа болно.
8. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн хэрэгжих хугацаа дуусч байгаатай холбогдуулан 2019 онд “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.3.5-р зүйлд тусгагдсанаар агаар, ус, хөрсний шинжилгээг хийлгэхээр дээж авч өгсөн байгаа болно.
9. Мөн зүйлд тусгагдсанаар 2018 оны гантай байсан улиралд ойр тойроны малчдыг усааар ханган, тэдний малыг усалж өгч байсан.
10. “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.4-р зүйлд тусгагдсанаар 2018 онд УБ хотоос 12-13 хүнийг, хөдөө орон нутгаас 5-6 иргэнийг /Баянжаргалан сумаас 1 гэр бүл тус уурхайд олон жил ажиллаж байгаа, Өндөршил сумаас 1 гэр бүл, Чойроос гэр бүлийн 3 хүн/ ажлын байраар ханган Нийгмийн даатгалд хамруулан ажиллуулдаг.
11. Уурхайд ажиллах хүсэл сонирхолтой иргэдийг авч ажиллуулахад бэлэн байдаг тухайгаа Баянжаргалан сумын холбогдох байгууллагуудад болон Иргэдийн төлөөлөгчдийн хуралд

оролцохдоо удаа дараа хэлж санал тавьж байдаг боловч тухайн сум орон нутгаас тус уурхайд ажиллах хүсэлтэй иргэд байдаггүй. Гэхдээ 2018 оны 7-р сараас 10-р сарын хооронд жонш ялган сортлох ажилд Баянжаргалан сумаас болон ойролцоох хөдөө, орон нутгаас 5-7 хүний бүрэлдхүүнтэй 2 бригадыг хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулсан.

12. “Хамтран ажиллах гэрээ”-ний 4.6-р зүйлд тусгагдсанаарманай уурхайн ойр амьдардаг орон нутгийн малчидаас мах, сүү гэрээлэн авч уурхайн ажилчдынхаа хэрэгцээг ханган, чадлынхаа хэрээр малчидтайгаа хамтран ажилладаг болно.
13. Үнэн Анд ХХК нь 2019 онд Баянжаргалан сумын 2-р багийн 50 айл өрхөд тус бүр 5тн нүүрс худалдан авч өгөхөөр тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оролцохдоо багийн иргэдэд амласан байгаа бөгөөд энэ талаар ирэх оны “Хамтран ажиллах гэрээ”-нд тусгуулахаар төлөвлөж байгаа болно.



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

Утас: 91114056

Хаяг: Дундговь аймаг

Мандалговь хот,

Аймгийн Засаг даргын Тамгын газар

ГЭРЭЭГ ДҮГНЭСЭН:

ҮНЭН-АНД ХХК-НИЙ
ЗАХИРАЛ

М.Төмөрсоль Т.ТӨМӨРСОЛЬ



Утас: 88114980

Хаяг: Улаанбаатар, СБД

2-р хороо, 5-р хороолол, 32-96 тоот

Мэйл хаяг: tumursoli@yahoo.com